

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 4-р сарын 30-ны өдөр

Дугаар 01/26

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн саналын
дүнг батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Монноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/26 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын Т-01/26 тоот тэмдэглэлийн шийдвэр хэсгийн 1 дүгээрт заасныг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 245316 санал буюу 100%-ийн саналаар Компанийн 2025 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг баталсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, “Компанийн тухай хууль”-ийн 83 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ТУЗ-д сар бүр ажлаа дүгнүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-д үүрэг болгосугай.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



П.Оюунбаяр

Д.Даваасүрэн

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 4-р сарын 30-ны өдөр

Дугаар 02/26

Улаанбаатар хот

Компанийн удирдлагыг сонгож
батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дугаар заалт, “Монноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/26 тоот тогтоол, ХЭХ-ын Т-01/26 тоот тэмдэглэлийн шийдвэр хэсгийн 2 дугаарт заасныг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн
245316 кумулятив санал буюу 11%-ийн саналаар С.Мөнхжаргалыг,
245316 кумулятив санал буюу 11%-ийн саналаар Ж.Болдбаатарыг,
245316 кумулятив санал буюу 11%-ийн саналаар С.Алимааг,
245316 кумулятив санал буюу 11%-ийн саналаар М.Тунгалагийг,
245316 кумулятив санал буюу 12%-ийн саналаар П.Оюунбаярыг тус тус Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн энгийн гишүүнээр,
245316 кумулятив санал буюу 11%-ийн саналаар Билл Холдсвортыг,
245316 кумулятив санал буюу 11%-ийн саналаар Б.Мэдрээг,
245316 кумулятив санал буюу 11%-ийн саналаар И.Сэр-Одыг,
245316 кумулятив санал буюу 11%-ийн саналаар Т.Батмагнайг тус тус
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосныг тус тус баталсугай.
2. “Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж,
компанийн үйл ажиллагааг удирдлага хяналтаар хангаж ажиллахыг Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн дарга /Билл Холдсворт/-д зөвшөөрсүгэй.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



П.Оюунбаяр

Д.Даваасүрэн

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 4-р сарын 30-ны өдөр

Дугаар 03/26

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах ТУЗ-ийн
шийдвэрийг дэмжих тухай

“Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйл, компанийн ногдол ашгийн бодлогын тухай журам, ТУЗ-ийн 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01/26 тоот тогтоолоор гаргасан шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/26 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын 01/26 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 3 дэх заалтыг үндэслэн **ТОГТООХ** НЬ:

1. Компанийн удирдлагын зардлын төсвийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 245316 санал буюу 100%-ийн саналаар 2025 оны ногдол ашгийг нэгж хувьцаанд 80 төгрөгөөр тогтоосон ТУЗ-ийн 02/26 тоот тогтоолыг дэмжсүгэй.
2. Ногдол ашигт зарцуулагдах 28,070,160 /Хорин найман сая далан мянга нэг зуун жаран/ төгрөгийг компанийн ашгаас гаргахыг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-т зөвшөөрсүгэй.
3. Компаниас гаргах мөнгөн хөрөнгийг 2026 оны 5 дугаар сарын 31-ны дотор Ногдол ашигийг нийтэд зарлан, тараах ажлыг зохион байгуулан гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-т даалгасугай.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



П.Оюунбаяр

Д.Даваасүрэн

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 4-р сарын 30-ны өдөр

Дугаар 04/26

Улаанбаатар хот

Компанийн удирдлагын зардлыг
батлах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 62.1.13 дугаар зүйл, хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/26 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын 01/26 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 3 дэх заалтыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн удирдлагын зардлын төсвийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 245316 санал буюу 100%-ийн саналаар 6,560,000 төгрөг /Зургаан сая таван зуун жаран мянган/-өөр баталсугай.
2. Батлагдсан төсөвт багтаан компанийн удирдлагын зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-д, зардлын зарцуулалтын үнэн зөв байдалд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг ТУЗ-ийн дарга /Билл Холдсворт/-д тус тус даалгасугай.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



П.Оюунбаяр

Д.Даваасүрэн